

© “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл 2021

МОНГОЛ ДАХЬ ОРОС ХЭЛНИЙ СУРГАЛТ: ӨНӨӨ БА ИРЭЭДҮЙ

Ж.Соронзон¹

Монгол Ардын Засгийн газар, Зөвлөлт Оросын Засгийн газрын хооронд найрсаг харилцаа тогтоох тухай Гэрээг 1921 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр байгуулан, дипломат харилцаа тогтоосноос хойш тал бүрийн хамтын ажиллагааг тасралтгүй хөгжүүлсний нэг нь боловсролын хамтын ажиллагаа.

Энэхүү хамтын ажиллагаа 1922 оноос монголын анхны 15 хүүхэд Орос Улсын их, дээд сургуульд суралцсанаар эхэлсэн гэж үздэг.² Харин боловсролын хамтын ажиллагааг өргөн хүрээнд, тодруулбал, оросын ард түмний хэл, соёлыг албан ёсоор судалж эхэлснээс тооцон үзвэл түүнээс ч өмнө гэж хэлэх үндэстэй.

“Богд хаант Монгол Улсын хууль зүйлийн бичиг”-т дунд зэргийн сургуульд орос хэл бичгийг сайтар мэдэж боловсруулна³ хэмээн заасны дагуу ерөнхий боловсролын сургуульд нийтээр орос хэлийг судлах хичээлийн жагсаалтанд анх орсон байна. Ийнхүү нийтээр орос хэлийг судлах асуудлыг тухайн үеийн хамгийн гол хуульд тусган хуульчилсан нь Богдхаант Монгол Уулсын төрийн бодлого бөгөөд түүнийг хэрэгжүүлэх арга ажиллагааны хүрээнд орос-монголын хооронд боловсрол, соёлын хамтын ажиллагаа, солилцоо байсныг илтгэн харуулна.

Тийм ч учраас монгол-оросын хэл соёлын хамтын ажиллагаа нь БНМАУ-ын үеэс өмнө Богд хаант Монгол улсын үеэс эхтэй гэж хэлмээр байна.

Тэр цагаас хойш монголчууд орос хэлийг судалж, түүгээр дамжуулж дэлхийн шинжлэх ухааны өв сангаас суралцсаар иржээ. Монголчуудын боловсролын түвшин дэлхийд гологдохооргүй түвшинд хүрсэн нь чухамхүү орос хэлийг нийтээрээ судалж ирсний үр дүн юм. Монголчууд орос хэлээр дамжуулан дэлхийн шинжлэх ухаан, техник, соёлын өвтэй танилцах төдийгүй түүний үр шимийг хүртэж, монгол үндэстэн, монголын хөгжлийг шинэ замд гаргахад түүхэн үүрэг гүйцэтгэсэн билээ. Үүний улмаас монголчууд “хэлтэй бол хөлтэй” гэсэн хэлц үгийг хэлэхэд хүрсэн бизээ.

¹ Монгол-Оросын хамтарсан сургуулийн захирал, доктор (Ph.D)

² А.Нямдолжин. Монгол-Оросын боловсролын хамтын ажиллагаа, хэтийн төлөв // https://www.researchgate.net/publication/332892209Cooperation_perspectives_on_education_sector_of_Mongolia-Russia

³ Богд хаант Монгол Улсын хууль зүйлийн бичиг. 7.6.

Бага, буурай хөгжилтэй үндэстэнд гадаад хэл хөгжлийн нэг чухал хөшүүрэг байсаар ирлээ. Тэд л том үндэстний хэлийг сурч, түүгээр дамжуулж соёлын солилцоонд орж, дэлхийн шинжлэх ухаан, техник, технологийн ололтоос суралцаж, улс орноо хөгжүүлсэн түүхтэй. Монголчууд орос, хятад гэсэн хоёр том гүрний дунд оршиж ирсэн атлаа орос хэл, соёлд илүү ач холбогдол өгч, орос хэлийг бүх нийтээрээ чамгүй өндөр төвшинд сурсан бие даасан үндэстэн байна.

Монголчууд хэдийгээр азийн үндэстэн боловч ази руу бус, харин өрнөд рүү нэлээд эртнээс хараа салгалгүй байсан азийн цөөхөн үндэстний нэг байж мэднэ. Энэ эрмэлзэл нь XIX сүүлчээс бүр ч тод илрэх болсон байна. Оросын эрдэмтэн И.М.Майский монголчууд өрний соёл иргэншилд илүү их ач холбогдол өгч байсныг тодорхойлон бичихдээ: “Хятадын соёлын өгөрч хуучирсан байдлыг бүдэг бадаг мэдрэх болж, хэдийгээр өнөө хэр олигтой нэвтрээгүй байгаа ч умардын соёлыг шинэ бөгөөд илүү, итгэл дүүрэн эрүүл юм гэж үзэж эдүгээ голдуу тийшээ харах болжээ”⁴ хэмээн тэмдэглэжээ. Түүгээрч барахгүй тэрээр: “европын илүү өндөр соёлыг харьцангуй төвөг багатай хүлээн авах чадвар боломж нь энэ овог аймгуудад байгааг амьдрал дээр нэг тод жишээгээр харуулъя хэмээн дурьдаад тэрхүү жишээндээ хүн малын өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг хийхэд орос оронд асар их эсэргүүцэлтэй тулгарч байсан бол европын эдгээр их “нээлтийг” монголчууд богино хугацаанд үр дүнг ухамсарлан ойлгож, дуртаяа нэвтрүүлсэн билээ”⁵ хэмээн дүгнэн бичжээ. Энэ мэт монголчуудаас өрнө дахин руу хандсан, өрний хэл, соёлд илүү ач холбогдол өгсөн түүхийн баримтыг олныг дурдаж болно.

Өрнө дахин руу түлхүү харж, хандаж ирсний улмаас монголчууд Азийн улсууд дотроос илүү өрнөжсөн үндэстэн болсон нь эерэг, сөрөг талтай хэдий ч алдсанаас оносон нь илүү болов уу. Монголчуудыг энэхүү сонголтыг хийхэд түүхэн хөрш оросын ард түмний хэл, соёл, иргэншлийн нөлөө шийдвэрлэх нөлөөтэй байсан гэдэг нь эргэлзээгүй юм.

Аливаа үндэсний соёл нэвтрэхэд хэл нь түүний зөөгч болж байсан маргаангүй үнэн юм. Энэ л зүй тогтлоор орос хэл оросын төдийгүй европын соёлыг монголд нэвтрүүлэхэд гүүр болсон түүхэн гавьяа бүхий хэл юм. Тийм учраас монголын орчин цагийн хөгжилд орос хэлний гүйцэтгэсэн үүрэгтэй маргах хүн өдгөө бараг үгүй бизээ.

Социалист байгуулалтын он жилүүдэд орос хэлийг бүх нийтээр сурах гэж үндэснийхээ уламжлалт үсэг соёлыг хүртэл өөрчилж, аав, ээжийгээ “маам”, “пап” гэж дуудаж, нэг ёсондоо орос хэлийг “хэтэртэл” нь судалж, төрөлх хэлнээс бараг дээгүүр тавихад хүрч байсан нь бас л бидний туулж өнгөрүүлсэн зам мөр юм.

⁴ Майский И.М. Орчин үеийн Монгол (Автономит Монгол XX зууны гараан дээр). 102 дахь тал.

⁵ Мөн тэнд. 381 дэх тал.

Гэтэл өнөөдөр орос хэл энэ байр сууриа аль хэдийн алджээ. Мэдээж монгол улс нээлттэй болсноор дэлхийн бусад том хэлийг судлах нь гарцаагүй шаардлага байсан нь эргэлзээгүй. Гэхдээ энэ нь орос хэлний орон зайг багасгах тийм ч хүчтэй шалтгаан бас биш юм.

Аливаа үндэстэн хөршийгөө сонгодоггүй шиг хөршийн хэлийг ч бас сонгохгүй. Монгол Улс далайд гарцгүй ч, далай шиг хоёр том хөрштэй. Энэ хоёр том хөршийн хэл Монгол Улсын боловсролын тогтолцоонд тусгай статустай байж болохгүй гэж үү.

Энэ талаас харвал хөршийн хэл, түүний дотроос орос хэлний түүхэн үүрэг, ач холбогдол зөвхөн боловсролын солилцооны асуудал бус, харин төрийн бодлогын асуудал юм.

Орос хэлийг ерөнхий боловсролын сургуульд сонгож үздэг болсон, их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрөөс хассан зэргээс улбаалан өдгөө орос хэлний орон зай өдрөөс өдөрт хумигдаж, орос хэлний сургалт хэрэг дээрээ бараг зогсож, ор нэр төдийхэн зүйл болсон нь нууц биш юм. Монгол Улсын хэмжээнд орос хэл мэддэг хүн улам бүр ховордсоор байна. Тодруулбал, Монгол-Оросын хамтарсан сургуулийн сурагчдын нийт 3400 орчим эцэг, эхийн таван хувь нь орос хэл хагас дутуу мэддэг гэсэн судалгаа гарсан. Хэрэв хөршийн хэл тусгай статустай байх талаар төрийн бодлоготой байсан бол нөгөө талаас манай хөршийн зүгээс хэл, соёлоо түгээн дэлгэрүүлэх талаар илүү их чармайсан бол монгол дахь орос хэлний орон зай ийнхүү эзгүйрэхгүй байсан буй заа.

Гэтэл бид хоёр талаасаа чармайхын оронд урьдын улс төр, үзэл суртлын хуучин арга, сэтгэлгээгээр хандаж байгаагийн улмаас хоёр ард түмнийг холбож байсан асар том гүүр ийнхүү нуран унахад хүрсэн байна. Бид монгол-оросын хамтарсан сургуулийн эцэг, эхийн дунд жил бүр явуулдаг судалгааны дүнгээс үзэхэд тухайн сургуулийг сонгосон шалтгааныг тандан судлахад орос хэлийг судлах, цаашид ОХУ-д суралцах шалтгаантай гэсэн хувь хэмжээ маш бага хувь хэмжээ эзэлдэг. Энэ бол харамсалтай мэдээ юм.

Дэлхийн өндөр хөгжилтэй улс орнууд өөрийн хэл соёлыг хил хязгааргүйгээр түгээн дэлгэрүүлэхэд асар их ач холбогдол өгч, хүч чармайлт тавьж байна. Энэ чармайлтыг ашиглаж, манай сургууль бусад гадаад хэлийг судалж байна. Харин манай умард хөрш энэ талаар тийм ч хүчтэй бодлого явуулсангүй. Бидний зүгээс ОХУ-д дахь шилжилтийн амаргүй сорилтуудыг туулсны дараа уг асуудалд анхаарлаа хандуулах байх гэж цөөнгүй жил хүлээсэн, одоо ч хүлээсээр байгаа билээ. Харин Москва, Улаанбаатарын Тунхаглалд орос хэлний асуудлыг тусгайлан заасан нь цаашид орос хэлний сургалт өргөжинэ гэсэн найдлагыг төрүүлсэн ч одоогоор тодорхой, бодитой үр дүн гараагүй байна.

Хүчирхэг эдийн засагтай ОХУ-ын хувьд өөрийн түүхэн хөрш монгол дахь орос хэлний сургалтыг тал бүрээр дэмжих, хилийн чандад байгаа цөөн орос

сургуульд санхүүгийн болон бусад туслалцаа үзүүлэх нь тийм ч болж бүтэхгүй, хүнд хүчир ажил биш юм.

Өдгөө манай оронд хувийн хэвшлийн орос хэлээр сургалтаа явуулдаг сургууль үндсэндээ байхгүй боллоо. Зөвхөн монгол-оросын хамтарсан сургууль болон ОХУ-ын Элчин сайдын яамны дэргэдэх сургууль л үлдлээ. Монгол-Оросын хамтарсан дунд сургуульд 2700 орчим, ОХУ-ын Элчин сайдын яамны дэргэдэх сургуульд болон Плехановын лицейд цөөн сурагч суралцаж байна. Одоо орос хэлний сургалттай нэг сургууль Улаанбаатар хотод байгуулах тухай яригдаж байгаа хэдий ч түүний тухай ярихад бас эрт байна. Олон асуудал нь шийдэгдээгүй байгаа бололтой. Үүнтэй зэрэгцэн англи, бусад хэлээр сургалтаа явуулдаг сургуулиуд ч мөн олноор байгуулагдаж байна. Энэ өрсөлдөөн орос хэлний сургалттай сургуулиудын гадуур өрнөх нь одоо нэгэнт тодорхой болжээ. Орос хэл, оросын боловсролыг үнэлэх монголын хэрэглэгчдийн үнэлгээ ийнхүү буурах болсон нь оросын боловсролын үнэлгээ буурсанд бус, харин орос хэлний цар хүрээ хумигдсан, түүнээс хамаарсан мэдлэг, мэдээллийн хомс байдал нөлөөлсөн ажээ.

Монгол дахь орос сургуулиудийн өмнө тулгарч байгаа бэрхшээл өмчийн хэлбэрээс хамааралгүйгээр адил байгаа юм. Энд тухайн сургуулийн дотоод зохион байгуулалт, сургалтын бодлого, менежмент зэргээс хамааралтай олон асуудал, бэрхшээл байгаа хэдий ч тэр нь шийдэж болохгүй асуудал огт биш юм. Хамгийн гол бэрхшээл – багшийн асуудал мөн. Монголд олон орос сургууль нээгдэж, бас чамлахааргүй ажиллаж байсан нь оросын боловсролыг үнэлдэг хэрэглэгчдийн хэрэгцээ байсны зэрэгцээ оросын хөдөлмөрийн зах зээлд харьцангуй хямд ажиллах хүчин – багш байсантай шууд холбоотой байлаа. Одоо эл байдал эрс хүчтэй өөрчлөгдөж байгаа нь монгол дахь орос сургуулиудын хувь заяаг шийдэх хүчин зүйл боллоо.

ОХУ-д “Национальный проект образования” төслийн хүрээнд боловсролын шинэтгэл маш эрчимтэй хэрэгжиж, багшийн хөдөлмөрийн чанар, үр дүнгээр цалинг ялгавартай олгодог тогтолцоонд шилжсэнээр багшийн нийгмийн үнэлгээг эрс дээшлүүллээ. ОХУ-ын улсын төсвөөс сургуульд өгч байгаа төсвийн 65 хувь нь суурь цалинд, 35 хувь нь сургуулийн захиргаа багшийн хөдөлмөрийн чанар, үр дүнгээс хамааруулан нэмэгдэл цалин олгох тогтолцоонд шилжихээр болж байна. Энэ төслийн хүрээнд сайн багшийн цалин сард 80,000-90,000 рубль буюу 1,000–1,100 ам.долларт хүрээд байна. Ийм хэмжээний цалинг ОХУ-ын нийт багшийн арван хүний нэг нь авах бололцоотой гэсэн тооцоо судалгааг ч оросын судлаачид гаргажээ. Эх орондоо ийм цалин авах бололцоо бий болж байхад биднээс 300–500 ам.долларын цалин авах гэж хэн бидэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах нь нэн ойлгомжтой асуудал юм.

Өөрийн хямд ажиллах хүчнийг ашиглан монгол багштай орос сургууль

байж болно гэж төсөөлж болох боловч хэрэглэгчид түүнийг зөвшөөрөхгүй нь лавтай. Орос багшгүйгээр орос сургуулийг төсөөлөх бас бололцоогүй юм. Тэгэхлээр, энэ гарц ирээдүйгүй нь шууд харагдана.

ОХУ-д багшид өгч байгаа цалинг монголд өгөх бололцоо ойрын ирээдүйд ч байхгүйгээр үл барам ОХУ-д сайн багшид өгч байгаа цалингийн хагасын талаар ч багш цалинжуулах бололцоо монголд байхгүй юм. Тийм хэмжээний мөнгөний эх үүсвэрийг олох бололцоо монголд байхгүй тул орос сургуулиуд үйл ажиллагаагаа зогсоож байгаа нэг хүчин зүйл энэ байна.

Орос хэлийг сургах, сурах үйл явц нь хэрэглэгчдийн хэрэглээний ач холбогдолтойгоос гадна хоёр ард түмний найрамдал, хамтын ажиллагааны хамгийн найдвартай бат бэх гүүр гэдгийг бид ойлгох ёстой.

Дэлхийд хөл тавиулсан, нүд нээсэн орос хэлээ монголчууд мартаж болохгүй. Манай зарим судлаачдын ажигласнаар монголчууд шинжлэх ухааны болон бусад салбарын нарийн мэргэжлийн мэдээллийг орос хэлээр чөлөөтэй ойлгодог шиг англи хэлийг суртал даруй 50 жил хэрэгтэй гэж үзсэн нь бас бодууштай асуудал юм. Монголчууд ч орос хэл сурах эрмэлзэл байсаар байна. Тийм учраас ерөнхий боловсролын сургууль дахь орос хэлний хичээлийн үнэлэмж, чанарыг сайжруулах, багш нарын мэргэжлийг ОХУ-д байнга тогтмол дээшлүүлэх, орос хэлний багш нарын мэргэжлийг дээшлүүлэх хамтарсан хүрээлэнг монголд байгуулах, БНХАУ-ын Кунзийн хүрээлэн шиг сайн дурын багш нарыг ОХУ-аас урьж ажиллуулах зэрэг хойшлуулшгүй ажил хоёр талын хамтын хүчин чармайлтыг хүлээж байна.

Нөгөө талаас орос хэл, оросын соёл, боловсролыг үнэлдэг монголын үнэлэмж, хэрэгцээг ОХУ ч алдаж болохгүй боломж юм. Дэлхийн өндөр хөгжилтэй гүрнүүд тийм хэрэгцээ, үнэлэмжийг буй болгох гэж асар их цаг хугацаа, хөрөнгө хүч, чармайлт гаргаж байна.

Тийм учраас Монгол, Оросын ард түмний хамтын ажиллагааны мөнхийн гүүр болсон орос хэл, түүний монголын боловсролын тогтолцоонд эзлэх байр суурь, ирээдүйн хувь заяа нь хоёр орны төрийн бодлогын төвд байх ёстой, шийдэл хүлээсэн асуудал болсон мэт санагдана.

Анхаарал тавьсанд баярлалаа.